

АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах
зөвлөлийн 2019 оны 02 дүгээр
сарын 17-ны өдрийн 17/02 тоот
тогтоолын 3-р хавсралтаар батлав.

АПУ ХК-ААС БАРИМТЛАХ ДОТООД ХЯНАЛТЫН БОДЛОГО

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү баримт бичгийг Монгол Улсын Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексийн хүрээнд нээлттэй хувьцаат компанийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагад нийцүүлэн боловсруулав.
- 1.2. Энэхүү бодлогын зорилго нь АПУ ХК (цаашид “компани” гэх)-ийн үйл ажиллагаа нь хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмын дагуу явагдаж байгаа эсэх, санхүүгийн мэдээллийн үнэн зөв байдлыг хангахад чиглэсэн нягтлан шалгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Дотоод хяналт

- 2.1. Дотоод хяналт гэж хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмын нийцтэй байдал, санхүүгийн мэдээллийн үнэн зөв байдлыг нягтлах, хяналт шалгалтын үйл ажиллагааг ойлгоно.
- 2.2. Компани нь бүхий л түвшинд эрсдэлд суурилсан дотоод хяналтын үйл ажиллагаа явуулах бөгөөд дотоод хяналт нь дараах чиглэлтэй байна. Үүнд:
 - 2.2.1. Компанийн хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн биелэлт болон нийцэлд хяналт тавих;
 - 2.2.2. Нөөцийн ашиглалтын үр ашигтай болон үр дүнтэй эсэхэд хяналт тавих;
 - 2.2.3. Үйл ажиллагааны болон санхүүгийн тайлагналын үнэн зөв байдалд хяналт тавих;
 - 2.2.4. Эрсдэлийг үр ашигтай удирдаж байгаа эсэхэд хяналт тавих;

Гурав. Дотоод хяналтын зарчим

- 3.1. Дотоод хяналтыг гүйцэтгэхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:
 - 3.1.1. **Хуулийг дээдлэх:** Хяналт шалгалтын үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулах;
 - 3.1.2. **Хараат бус байх:** Төв голч, үнэнч шударга хандлагатай байж, сонирхлын зөрчлөөс ангид хараат бус байх;

- 3.1.3. **Шударга байх:** Шалгалтанд хамрагдаж буй аливаа алба хэлтэс, нэгжид шударга хандахын зэрэгцээ хяналт, шалгалттай холбоотой асуудлаар тайлбар гаргах эрхээр хангах;
- 3.1.4. **Бодитой байх:** Хяналт, шалгалтанд аливаа хөндлөнгийн зүйлд автахгүйгээр зөвхөн хуулийн хүрээнд ажилладаг байх;
- 3.1.5. **Мэргэжлийн ур чадвартай байх:** Харилцааны болон мэргэжлийн ур чадварыг эзэмшсэн байх;
- 3.1.6. **Тэгш хандах:** Шалгуулагч бүрт адил нөхцөл байдалд ижил хандах;
- 3.1.7. **Нууцыг хадгалдаг байх:** Өөрийн үүргээ гүйцэтгэхээс бусад тохиолдолд шалгуулагчийн талаарх мэдээллийг задруулахгүй байх;
- 3.1.8. **Туслалцаа үзүүлдэг байх:** Хууль тогтоомжийн талаар зөвөлгөө, туслалцаа үзүүлдэг байх;
- 3.1.9. **Хөндлөнгийн байх:** Дотоод хяналтын үйл ажиллагааг явуулахдаа хөндлөнгийн байр сууринаас хандах;

Дөрөв. Дотоодын хяналтын үйл явц

4.1. Дотоод хяналтын үйл явц нь дараах үе шаттайгаар хэрэгжинэ. Үүнд:

- 4.1.1. Хяналтын орчныг үнэлэх;
- 4.1.2. Эрсдэлийн үнэлгээ хийх;
- 4.1.3. Хяналтын үйл ажиллагаа явуулах;
- 4.1.4. Мэдээлэл, харилцаа холбоог зохистой ашиглах;
- 4.1.5. Хяналт, мониторинг хийх;
- 4.1.6. Тайлагнах;

Тав. Дотоод хяналтын хэрэгжүүлэлт

- 5.1. Дотоод хяналтыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх), Гүйцэтгэх захирал ба Гүйцэтгэх захирлын дэргэдэх Дотоод хяналтын алба хэрэгжүүлнэ.
- 5.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь дараах байдлаар дотоод хяналтын үйл ажиллагааг хариуцна.
 - 5.2.1. Дотоод хяналтын бодлогыг тодорхойлох, батлах, түүнийг өөрчлөн сайжруулах;
 - 5.2.2. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороогоор дамжуулан дотоод хяналтын үйл ажиллагаанд хяналт тавих;
- 5.3. Гүйцэтгэх захирал нь дараах байдлаар дотоод хяналтын үйл ажиллагааг хариуцна.
 - 5.3.1. Дотоод хяналтын бодлогын дагуу дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх Дотоод хяналтын алба байгуулж, түүний ажиллах журам, зарчим, дүрмийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх;
 - 5.3.2. Дотоод хяналтын төлөвлөгөөг боловсруулах, батлах;
 - 5.3.3. Дотоод хяналтын албаны ажлыг дүгнэх;



- 5.4. Дотоод хяналтын алба нь дараах байдлаар дотоод хяналтын үйл ажиллагааг хариуцна.
- 5.4.1. Дотоод хяналтын үйл ажиллагааг хууль тогтоомж, батлагдсан бодлого, дүрэм, журам, стандартын дагуу гүйцэтгэх;
- 5.4.2. Компанийн өндөр эрсдэлтэй хэсгүүдэд чиглэн ажиллах;
- 5.4.3. Дотоод аудитын үйл ажиллагааны тайланг Гүйцэтгэх захиралд тайлагнах;

Зургаа. Хяналт, сайжруулалт, өөрчлөлт оруулах

- 6.1. Дотоод аудитын хорооноос дотоод хяналтын үйл ажиллагаанд аудит хийж түүнээс гаргасан үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжийн дагуу дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулна.
- 6.2. Дотоод аудитын хорооноос гаргасан дүгнэлт, зөвлөмж, Төлөөлөн удирдах зөвлөл, түүний дэргэдэх Аудитын хороо, Гүйцэтгэх захирлын саналд үндэслэн дотоод хяналтын бодлогод өөрчлөлт оруулна.

--- 000 ---

